



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 01/228

Ховд

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а” заалтыг үндэслэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн н/01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Ховд суварга” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй сүмийн барилгыг Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газарт шилжүүлэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Л. Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн


Л.Хатанбаатар - “Ховд суварга” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

М.Энхтайван - Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газрын ахлах ажилтан, дэд хурандаа

Нарийн бичгийн дарга: Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

2. Барилгыг хууль тогтоомжийн дагуу баримт үйлдэн хүлээлцэхийг ажлын хэсгийн ахлагч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



02 01127 D/Зах-А/228-Да